



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 72,496,615.00 (далан хоёр сая дөрвөн зуун ерэн зургаан мянга зургаан зуун арван таван) төгрөгийн балансын үнэ бүхий 8 ширхэг автомашин (мотоцикл)-ыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Автомашин нэр, улсын дугаар, арлын дугаар	Авто машины улсын дугаар	Нийт гүйлт /км/	Ашиглалтад орсон он сар өдөр	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	
Дотоодын цэргийн 805 дугаар анги							
ондай соната-5, 65-56 УБГ (3855KMHEN41AP4A)	65-56 УБГ	303654	12/25/1999	12,628,500.00	12,628,500.00	-	
ондай соната-5, 76-85 УБГ (MHEM41AP1A-578150)	76-85 УБГ	409739	12/25/2001	10,000,000.00	10,000,000.00	-	
Сүүж-Уул амралт сэргээн засах сувилал							
ёото ландкрузер-105, 02-70 УБУ (C1800035232)	02-70 УБУ	535807	1/1/2002	45,000,000.00	45,000,000.00	-	
НХЖХ, ОНАБХА-ны Эргүүл хамгаалалтын газар							
тоцикл (policy ХУ-150, эхг, 2FNMJ7L050002)	00-01	5600	9/3/1909	1,200,000.00	1,200,000.00	-	
тоцикл (policy ХУ-150, эхг, 2FNMJ7L050019)	00-02	6200	9/3/1909	1,200,000.00	1,200,000.00	-	
тоцикл (policy ХУ-150, эхг, 2FNMJ7L050003)	00-03	6500	9/3/1909	1,200,000.00	1,200,000.00	-	
тоцикл (policy ХУ-150, эхг, 2FNMJ7L050007)	00-04	5800	9/3/1909	1,200,000.00	1,200,000.00	-	
Хангалт үйлчилгээний төв							
тоцикл (ЗХИ-003130)	-	5100	7/1/1985	68,115.00	68,115.00	-	
Дүн				72,496,615.00 (далан хоёр сая дөрвөн зуун ерэн зургаан мянга зургаан зуун арван таван төгрөг)			6,650,000 сая зургаан мянга